Газрын гадаргын ерөнхий төрхийг уулархаг гадарга зонхилж тэдгээрийн хоорондох өргөн нарийн ам, хөндийнүүд бүрдүүлнэ. Нутгийн өмнөд хэсэгт Монгол Алтай болон Байтаг Богд уулын хооронд үүссэн Баруун хуурайн хотгор байдаг. Энэхүү хотгор нь 300 орчим километр урт, 100 км өргөн газрын гадарга нь тэгш биш олон цав толгод, нам шил гүвээнүүдтэй юм. Сумын тариалангийн гол газар нь Булган голын хөндий, Баянголын аманд байрлана.


Сумын гадаргын өндөржилтийн талбай

Хүснэгт 4.

Д/д	Өндөршилт /Метр/	Талбайн хэмжээ /га/	Эзлэх хувь
1	983-1200	171512.8	21.2
2	1200-1400	266325.94	32.9
3	1400-1600	142030.8	17.5
4	1600-1800	63439.83	7.8
5	1800-2000	43825.9	5.4
6	2000-2400	64190.37	7.9
7	2400-3392	59543.93	7.3
	Нийт	810869.57	100


Гадаргын гипсометрийн зүсэлт

Диаграмм 2.



Сумын гадаргыг баруун хойноос, зүүн урагшаа зүсэлт хийж үзэхэд хойд хэсгээрээ өндөр өргөгдсөн ба Булган гол орчим буюу дунд хэсгээрээ намсаж урагшлах тутам том хотгор ухаа гүвээт талд шилжиж Байтаг тал руугаа өндөрсөж тогтсон байна. Сумын төв нь голын хөндийд нам дор газар байрласан байна.

Зураг 4. Сумын газрын гадаргын өндөршилт




2.1.5. Байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцлийн мужлал.

Нутаг дэвсгэрийг геологийн бүтэц, уур амьсгал, хотгор гүдгэр, ус зүй, хөрс ба ургамшил, амьтны аймгийн хам бүрдлийн ялгаа, харилцан үйлчлэлийн ижил төстэй нөхцлүүдээр нь мужилж, ашиглалтын үндсэн чиглэлийг тодорхойлох нь газрыг шинжлэх ухааны үндэслэлтэй ашиглах нөхцлийг бүрдүүлдэг. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хүрээнд монгол улсын нийт нутаг дэвсгэрийг 4 том мужийг хүрээнд 31 тойргоор хувааж нөхцөл нөөцийг үнэлсэн байна. /Д.Даш, Ц.Бадам-УГЗБЕТ-2002/

Энэ үнэлгээгээр Ховд аймгийн Булган сумын нутаг дэвсгэр нь байгаль-нутаг дэсгэрийн цогцолбор нөхцөлийн мужлалаар бүхэлдээ Монгол Алтайн өндөр уулын мужийн Мөнххайрханы өндөр уулсын тойрог, Говь Алтайн уулсын мужийн Баруун хуурайн хотгорын тойрогт багтаж байна. Уг нутаг Өндөр уулын бүсийн уулс, цав толгод, ухаа гүвээт тал, уулс хоорондын хотгор хамарна.

Зураг 5. Геоморфологийн зураг




2.1.6. Гадаргын налуу.


Гадаргын хэвгийн хувьд 0-2 градусын хэвгий бүхий газар 62032.9 га буюу 7.6 хувь, 2-4 градусын хэвгий бүхий газар 129148.9 га буюу 15.93 хувь, 4-8 градусын хэвгий бүхий газар 234212.5 га буюу 28.88 хувь, 8-16 градусын хэвгий бүхий газар 207655.4 га буюу 25.61 хувь, 16-32 градусын хэвгий бүхий газар 90928.2 га буюу 11.2 хувь, 32-40 градусын хэвгий бүхий газар 78098.8 га буюу 9.63 хувь, 40-70.17 градусын хэвгий бүхий газар 8792.8 га буюу 1.08 хувь тус тус эзэлж байна. Газар тариалангийн аж ахуй эрхлэхэд тохиромжтой 0-4 градусын хэвгий бүхий газар нийт нутаг дэвсгэрийн 23.5 хувь, 4-8 градусын хэвгий бүхий газар нийт нутаг дэвсгэрийн 28.8 хувийг эзэлж байна.

Гадаргын хэвгийн эзлэх хувь

Диаграмм 3.




Зураг 6. Гадаргын хэвгийн зураг




2.1.7. Гадаргын зүг зовхис.

Гадаргын зүг зовхисийн хувьд сумын нутаг дэвсгэрийн 13.0 хувийг хойд зүг буюу 337.5-22.5 градусын зүг зовхис; 12.9 хувийг урд зүг буюу 157.5-202.5 градусын зүг зовхис; 12.7 хувийг зүүн зүг буюу 67.5-112.5 градусын зүг зовхис; 12.6 хувийг баруун зүг буюу 247.5-292.5 градусын зүг зовхис; 12.4 хувийг зүүн хойд зүг буюу 22.5-67.5 градусын зүг зовхис; 11.8 хувийг зүүн урд зүг буюу 112.5-157.5 градусын зүг зовхис; 11.9 хувийг баруун хойд зүг буюу 292.5-337.5 градусын зүг зовхис; 12.6 хувийг баруун урд зүг буюу 202.5-247.5 градусын зүг зовхистой гадарга тус тус эзэлж байна.

*Гадаргын зүг зовхис, эзлэх хувиар**Диаграмм 4.*

Зураг 7. Зүг зовхисын зураг



2.2. СУМЫН УУР АМЬСГАЛ

Сумын цаг уурын онцлогыг авч үзвэл эх газрын эрс тэс уур амьсгал ноёлно. Булган, Үенч-Бодонч зэрэг голын сав нутагт багтдаг. Жилийн дундаж температур 4,7 градус хүрдэг. Уур амьсгалын хувьд халуун зунтай хуурай мужид хамаардаг. Цаг уурын үзүүлэлтүүдээр авч үзвэл:

- 1 дүгээр сарын дундаж температур нь -19,7 °С
- 7 дугаар сарын дундаж температур +21,9 °С
- Агаарын үнэмлэхүй дулаан 35,5-40 °С дулаан, хамгийн хүйтэн нь 38-40 °С хүрдэг.
- Жилийн дундаж салхины хурд 1,6 м/с
- Жилийн хур тунадасны хэмжээ 95 мм тус тус байдаг байна.

2.2.1. Агаарын температур.

Тус суманд хоногийн болон улирлын агаарын температурын хэлбэлзэл ихтэй, өвөлдөө хүйтэн, зундаа халуун. Олон жилийн дундажаар жилийн агаарын дундаж температур 3,4 °С, хамгийн бага үнэмлэхүй температур -40 °С, хамгийн их үнэмлэхүй температур 37 °С байна.


Агаарын жилийн дундаж температур, °С

Хүснэгт 5.

Станцын нэр	Сарууд												Жилийн дундаж
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	
Байтаг	-13.6	-9.9	-2.3	8.4	15.2	19.0	23.0	20.2	10.8	4.8	-4.5	-15.4	4.7

Сумын агаарын жилийн дундаж температур, сараар

Диаграмм 5.




Сумын агаарын олон жилийн дундаж температур, °C

Хүснэгт 6.

Он	2011 он	2012 он	2013 он	2014 он	ОЖД
Жилийн дундаж	3,0	3,1	4,0	3,4	3,4

Сумын агаарын олон жилийн дундаж температур

Диаграмм 6.




Сумын хөрсний гадарга дээрх олон жилийн дундаж температур нь өвлийн 1, 2 дугаар сард -20,8 °C, хамгийн дулаан нь 7 дугаар сард 24,8 °C байгаа нь температурын зөрүү төдийлэн их бишийг харуулж байна. Энэ нь хадлан, бэлчээр болон таримал ургамлын ургалтанд сайнаар нөлөөлж байна.

Хөрсний гадарга дээрх олон жилийн дундаж температур, °C


Хүснэгт 7.

Станц	Сарууд												ОЖД
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	
Байтаг	-20.8	-15.3	-0.6	13.5	20.5	23.0	24.8	25.4	16.4	6.4	-6.6	-17.8	5.7

Хөрсний гадарга дээрх олон жилийн дундаж температур, °C Диаграмм 7.



Зураг 8. Агаарын температур




2.2.2. Хур тунадас.

Агаарын жилийн дундаж харьцангуй чийгшил 40-45%. Олон жилийн дундаж жилд унах хур тунадасны хэмжээ 335 мм унадаг. Жилийн хур тунадасны нийлбэр 95 мм хүрдэг байна.

Эндээс харахад тус сумын хувьд агаарын температур, чийгийн хангамж муугүй болох нь харагдаж байна


Сумын олон жилийн хур тунадасны үзүүлэлт

Диаграмм 8.



Өвлийн улиралд цасан бүрхүүлийн дундаж зузаан 4,5 см-ээс хэтэрдэггүй ба 11 дүгээр сарын сүүлчээс 3 дугаар сар хүртэл тогтвортой цасан бүрхүүлтэй байдаг.

Зураг 9. Хур тунадас




2.2.3. Салхи, салхины чиглэл.

Салхины зонхилох чиглэл Баруун болон баруун хойд, хойд зүгийн салхи зонхилдог ба олон жилийн дундаж хурд 1,6 м/с байна.


Тус сум нь салхины хүч багатай бөгөөд олон жилийн дунджаар 1,2-2,7 м/с хурдтай салхитай байна.

*Сумын ОЖД салхины хурд, м/с**Хүснэгт 8.*

Станц	Сарууд												ОЖД
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	
Байтаг	0.6	1.0	1.6	2.3	2.6	2.1	2.1	2.0	1.6	1.4	1.2	0.8	1.6

*Сумын ОЖД салхины хурд, м/с**Диаграмм 9.*

Зураг 10. Агаарын даралт



2.3. ХӨРС, ХӨРСӨН БҮРХЭВЧ**2.3.1. Хөрс үүсгэгч чулуулаг.**

Сумын нутгийн нилээд их хэмжээгээр буюу 79.9 хувьд элюви, делювийн хурдас тархсан ба дараа нь Элювийн хурдас бусад нь бага хэмжээгээр тархсан байна.

Сумын хөрс үүсгэгч эх чулуулаг, талбай, хувь

Хүснэгт 9.

Д/д	Код	Хөрс үүсгэгч эх чулуулаг	Талбайн хэмжээ /га/	Эзлэх хувь
1	801	Аллювийн хурдас	33942.8	4.2
2	802	Делювийн хурдас	9279.2	1.1
3	804	Элюви, делювийн хурдас	647483.6	79.9
4	808	Элювийн хурдас	117894.4	14.5
5	809	Эоловийн хурдас	2085.3	0.3
6	810	Нуурын хурдас	184.2	0.0
Нийт			810869.6	100


Элюви-делювийн хурдас нь уулархаг, намхан бэсрэг уулархаг, гүвээ цав толгодоор зонхилон тархана. Эдгээр хурдасны онцлог нь тэгш бус гадаргаар шилжин гулсах хөдөлгөөнд харьцангуй бага орж анхныхаа үүсэж тогтсон шинж чанар, төрх байдлаа хэвээр хадгалсан хурдсууд хамрагдана. Энэ хурдсуудын бүрэлдэхүүнд том хад чулуу хайрга хамрагдаж ихэвчлэн уулын орой хяр эгц налуу хажуугаар тархана.

Элювийн хурдас нь нутгийн 14.5 хувьд тархсан. Энэ хурдас нь голдуу уулын орой хяр нурууг дагаж том том хад чулуу, байц цохионуудын байдалтай тохиолдоно. Элювийн хурдасны онцлог нь нэг тогтсон байрандаа тогтмол байж байдаг онцлогтой бөгөөд түүний бүрэлдэхүүнд хад чулуунаас гадна элс хайр, шавранцар элсэнцэр хүртэл ихээхэн хэмжээгээр байна.


Аллювийн хурдас нь нутгийн 4.2 хувьд тархсан. Аллювийн хурдас нь голын хөндийн сав газар ялангуяа дэнж татам нуга, нуурын хөвөөгөөр элбэг тохиолдоно. Мөн голын дэнж уулын бэл хормойн хэсгээр аллювийн хурдас нь 0,5-1,5 м хүртэл зузаан үе давхаргыг үүсгэж тогтсон байна. Аллювийн хурдасны зузаан нь томоохон гол, нуурын хөндийд 10-15м хүртэл байх бөгөөд ихэвчлэн элс, хайрга, элсэнцэр, шавранцар механикийн бүрэлдэхүүнтэй байна. Зарим их намагтай газраа шаварлаг хурдас ихээхэн хэмжээгээр тархах боловч тэнд линз хэлбэрийн элс, хайрган давхаргыг үүсгэдэг байна. Эндэхийн томоохон голын хөндийнүүдэд ихэвчлэн дан хайргархаг-элсэнцэр, элсэнцэр хурдас зонхилж давсархаг карбонатлаг шинж чанарын хувьд янз бүр байна. Аллювийн хурдас нь өөрийнхөө бүрэлдэхүүнд том жижиг янз бүрийн хэмжээтэй бөөрөнхий хэлбэрийн хайрга чулуулгуудыг агуулан үелэн тогтсон байдлаараа онцлогтой байна.

Сумын хөрс үүсгэгч эх чулуулаг эзлэх хувь

Диаграмм 10.



Зураг 11. Хөрс үүсгэгч чулуулгийн зураг



2.3.2. Хөрсний хэв шинж.

Сумын хөрсөн нийт 24 хэв шинжийн хөрс тархсан бөгөөд хамгийн их тархсан хөрс нь 25.4 хувийг эзлэх хээржүү цөлийн цайвар бор хөрс бол дараа нь 19.2 хувийг уулын цөлөрхөг хээрийн бор хөрс, 13.8 хувийг өндөр уулын нугын карбонатгүй хар шороорхуу хөрс, 8.8 хувийг уулын цайвар хүрэн хөрс тус тус тархсан байна.

Сумын хөрсний хэв шинж /талбай-га, %/

Хүснэгт 10.

Д/д	Хөрсний код	Хөрсний нэр	Талбайн хэмжээ /га/	Эзлэх хувь
1	1105	Уулын тундрын хүлрэнцэр-глейт хөрс	2350.2	0.3
2	1215	Уулын ойн нугархаг бараан хөрс	2744.6	0.3
3	1301	Өндөр уулын толбот хээрийн бүдүүн ялзмагт хөрс	1511.9	0.2
4	1304	Уулын ердийн хар шороон хөрс /карбонатлаг биш/	4091.0	0.5
5	1402	Өндөр уулын нугын цэвдэгт хөрс	1606.2	0.2
6	1404	Өндөр уулын нугын карбонатгүй хар шороорхуу хөрс	112197.2	13.8
7	1503	Уулын цайвар хүрэн хөрс	71509.5	8.8
8	1601	Уулын цөлөрхөг хээрийн бор хөрс	155957.8	19.2
9	1602	Уулын цөлийн бор саарал хөрс	76462.5	9.4
10	2106	Нугын хүрэн хөрс	75.6	0.0
11	2204	Цайвар хүрэн хөрс	72198.5	8.9
12	2301	Цөлөрхөг хээрийн бор хөрс	10358.6	1.3
13	2302	Хээржүү цөлийн цайвар бор хөрс	205832.2	25.4
14	2303	Цөлөрхөг хээрийн нугат далд глейрхэг бор хөрс	15975.2	2.0
15	2305	Цөлийн бор саарал хөрс	23071.3	2.8
16	2308	Шалархуу хөрс	1601.4	0.2
17	3101	Нугын ердийн хөрс	41.5	0.0
18	3104	Нугын хээржсэн хөрс	8091.3	1.0
19	3105	Нугат-намгийн бүдүүн ялзмагт глейт хөрс /Нугат намгийн ялзмагт хөрс/	1165.0	0.1
20	3107	Нугат намгийн лаг шаварт хөрс /Цэвдэгт нугат намгийн лаг шаварт хөрс/	7999.9	1.0
21	3201	Аллювийн нуга-намгийн хөрс	32048.2	4.0
22	3206	Аллювийн нугын хөрс	1655.0	0.2
23	3209	Аллювийн нугын далд глейрхэг бараан хөрс	239.6	0.0
24	3405	Сулавтар бэхжсэн элсэн хөрс	2085.3	0.3
Нийт			810869.6	100.0

Хээржүү цөлийн цайвар бор хөрс: Энэ хэв шинжийн хөрс нь сумын нутаг дэвсгэрт 205832.2 га буюу нутаг дэвсгэрийн 25.4 хувийг эзлэн тархсан байна. Тус хөрс нь цайвар бор өнгөтэй, тоосорхог элсэнцэр механикийн бүрэлдэхүүнтэй, маш хэврэг бөөмөрхөг маягийн бүтэцтэй, сийрэгдүү тогтоцтой, ургамлын үндэс маш бага, карбонаттай, бага зэрэг чулуурхаг, чийг бага дараагийн В давхрагадаа өнгөөрөө тод шилжинэ. В үе давхарга нь шаргал туяатай бор өнгөтэй, элсэнцэр механикийн бүрэлдэхүүнтэй, бөөмөн маягийн

бүтэцтэй, нягтавттар тогтоцтой, карбонаттай, ургамлын үндэс маш бага, бага зэрэг чулуурхаг дараагийн С давхрагадаа өнгөөрөө тод шилжинэ.


Ийм хөрс илрэгдсэн зүсэлтүүдээс үзэхэд ялмагт үеийн зузаан 14-24см буюу дундажаар 18см байх бөгөөд физик шаврын агууламж 12,12-17,14% буюу дундажаар 14,95% байгаа нь элсэнцэр механикийн бүрэлдэхүүнтэй байна.

Ялмагт үеийн 0,7-1,0% буюу дундажаар 0,8%, ерөнхий азот 0,8% 0,03-0,07% буюу дундажаар 0,05%, 100гр хөрсөнд фосфор 0,76-1,44 мг буюу дундажаар 1,17 мг, кали 12,24-20,04 мг буюу дундажаар 16,47 мг, кальци магнийн нийлбэр 25,5-91,8 мг/экв буюу дундажаар 65,02 мг/экв байгаа нь байгалийн үржил шимээр ядмаг байна.

Уулын цөлөрхөг хээрийн хээрийн бор хөрс: Энэ хэв шинжийн хөрс нь сумын нутаг дэвсгэрт 155957.8 га буюу нутаг дэвсгэрийн 19.2 хувийг эзлэн тархсан байна. Уулын цөлөрхөг хээрийн сулавтар хөгжилтэй бор хөрс нь бор өнгөтэй, чийглэг ургамлын үндэс бага, механик бүрэлдэхүүн хэврэг тоосорхог, хөнгөн шавранцар, дараагийн үед өнгөөрөө тод шилжинэ. В үе давхарга нь цагаан цайвардуу өнгөтэй, ургамлын үндэс бага, механик бүрэлдэхүүн элсэнцэр чулуутай, тод шилжилттэй. Ялмагийн агууламж нь дээд үедээ 0,9-1,10% буюу дундажаар 1,0%, ерөнхий азот 0,02%, хөрсний орчин 7,8 буюу саармаг, 100гр хөрсөнд дундажаар солилцох кали 19,81мг, хөдөлгөөнт фосфор 2,86мг, шингээгдсэн сууриудын нийлбэр 39,11мг/экв байга.

Өндөр уулын нугын карбонатгүй хар шороорхуу хөрс: Энэ хэв шинжийн хөрс нь сумын нутаг дэвсгэрт 112197.2 га буюу нутаг дэвсгэрийн 13.8 хувийг эзлэн тархсан байна. Тус хөрс нь их төлөв уулын орой, мөлгөрдүүхэн хяр, таг тавцангуудаар бушилз, улалж бүхий ширэгжсэн тачирдуухан өвслөг ургамлын нөмрөгтэй гадаргад тархана. Хөрсний генетик морфологийн шинж чанарын хувьд ялмагт үеийн зузаан дундажаар 12-16 см, нягтарсан хүрэвтэр туяатай хар саарал буюу бараг харавтар өнгөтэй, бөөмөрхөг тоосорхог, сулхан үрлэн хэлбэрийн бүтэцтэй чийглэг ургамлын үндэс ихтэй, механик бүрэлдэхүүн нь их төлөв чулуурхаг, дунд шавранцар байна. Дараагийн үе давхарга В /12-30 см/ цайвардуу шаравтар бор хул өнгөтэй, нэлээд нягтарсан чулуурхаг, шавранцар механик бүрэлдэхүүнтэй бөгөөд доошлох дутам улам нягтарч чулуурхаг байдал нь ихэснэ.

Зураг 12. Хөрсний тархалтын зураг



2.3.3. Сумын хөрсний механик бүрэлдэхүүн.

Сумын нутаг дэвсгэрийн 62.2 хувийг элсэнцэр, 23.5 хувийг хөнгөн шавранцар, 14.0 хувийг дунд шавранцархамгийн бага буюу 0.2 хувийг хүнд шавранцар механик бүрэлдэхүүнээр эзлэн тархсан байна.


Сумын хөрсний механик бүрэлдэхүүн талбай, га

Хүснэгт 11.


Д/д	Код	Төрөл	Талбайн хэмжээ /га	Нийт нутаг дэвсгэрт эзлэх хувь
1	63	Хүнд шавранцар	1805.7	0.2
2	64	Хөнгөн шавранцар	190586.4	23.5
3	65	Дунд шавранцар	113863.2	14.0
4	66	Элсэнцэр	504614.2	62.2
Нийт			2799957.8	100

Сумын хөрсний механик бүрэлдэхүүний эзлэх талбай

Диаграмм 11.



Зураг 13. Хөрсний механик бүрэлдэхүүний зураг



2.4. УРГАМАЛЖИЛТ**2.4.1. Сумын ургамлын экологийн хэв шинж.**

Булган сумын гадарга нь өөр хоорондоо ялгаа бүхий ландшафттай бөгөөд нийт нутаг дэвсгэрийн 30 хувийг говь цөлийн бэлчээр ургамал, 25 хувийг өндөр уулын бэлчээрийн ургамал, 24 хувийг дундаж өндөр ба нам бэсрэг уул ургамлын бэлчээр, 11.5 хувийг цөлөрхөг хээрийн ургамал, 7.5 хувийг бүс дундын голын хөндийн, нам хотосын бэлчээрийн ургамал тус тус тархсан байна.


Сумын ургамалын экологийн хэв шинж

Хүснэгт 12.


Д/д	Экологийн төрөл	Талбайн хэмжээ /га/	Нийт нутаг дэвсгэрт эзлэх хувь
1	Өндөр уулын бэлчээрийн ургамал	202431.6	25.0
2	Дундаж өндөр болон нам, бэсрэг уулын бэлчээр ургамал	194360.2	24.0
3	Өндөр уулын хоорондох нуга хөндийн ургамал	1223.8	0.2
4	Цөлөрхөг хээрийн бэлчээр	93100.1	11.5
5	Говь цөлийн бэлчээр	243305.1	30.0
6	Бүс дундын голын хөндий, нам хотосын нугын бэлчээр	60420.6	7.5
7	Нуур	644.8	0.1
8	Ой	4978.1	0.6
9	Элс	9694.2	1.2
10	Мараа, шал	550.2	0.1
11	Хад асга	160.8	0.02
Нийт		810869.6	100

Сумын ургамлын экологийн хэв шинж, эзлэх хувиар

Диаграмм 12.



Зураг 14. Ургамлын экологийн хэв шинжийн зураг



2.4.2. Сумын бэлчээрийн ургамалжилт, төрөл.

Сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд 30 гаруй хэв шинжийн ургамалжилт илэрсэн байна. Үүнээс хамгийн түгээмэл тархсан ургамал 27.7 хувийг тэгшивтэр хөндийн бор, бор саарал хөрстэй говийн бэлчээрийн сийрэг загт, 21.1 хувийг өндөр уулын сул хөгжилтэй бүдүүн ялмагт хөрстэй сийрэг ургамалтай чулуурхаг хээрийн жижиг дэгнүүлт үетэн - алаг өвс – агьт ургамал тус тус тархсан байна.


Сумын бэлчээрийн ургамалын анги, төрөл зүйл

Хүснэгт 13.

Д/д	Зураг дээрхи индекс	Ангилалын шифр	Бэлчээр хадлангийн анги, бүлэг төрөл, төрлүүдийн нэр	Талбайн хэмжээ /га/
		<i>Ө-II</i>	<i>Анги: Уулын царамын хүлрэнцэр ялмагт, өндөр уулын нугын хар шороорхуу хөрстэй өндөр уулын нуга</i>	
1	4	Ө-II-1-1	Бушилж - улалжит, Улалж - бушилзат	138,0
2	5	Ө-II-1-2	Бушилзат	5832,6
		<i>Ө-III</i>	<i>Анги: Өндөр уулын нугат хээрийн болон бүдүүн ялмагт хөрстэй хээр</i>	
3	9	Ө-III-1-2	Жижиг дэгнүүлт үетэн - алаг өвс - бушилзат	25320,8
		<i>Ө-IV</i>	<i>Анги: Өндөр уулын сул хөгжилтэй бүдүүн ялмагт хөрстэй сийрэг ургамалтай чулуурхаг хээр</i>	
4	11	Ө-IV-1-2	Жижиг дэгнүүлт үетэн - алаг өвс - агьт	171140,2
		<i>У-VI</i>	<i>Анги: Уулын цайвар хүрэн ба бор хөрстэй цөлөрхөг хээр</i>	
5	61	У-VI-1-4	Монгол өвс - таанат	23520,7
6	64	У-VI-1-7	Монгол өвс - тэсэгт	3684,6
7	65	У-VI-1-8	Монгол өвс - бударганат	59157,7
8	66	У-VI-1-9	Монгол өвс - баглуурт	17846,8
		<i>У-VII</i>	<i>Анги: Уулын бор, бор саарал хөрстэй говь цөлийн бэлчээр</i>	
9	71	У-VII-1-1	Баглуур - монгол өвст	7127,9
10	72	У-VII-1-2	Баглуурт, баглуур - бударганат	9797,4
11	73	У-VII-1-3	Бударгана - монгол өвст	73225,0
		<i>ӨХ-I</i>	<i>Анги: Уулсын хоорондох хөндийн цэвдэгт нугат намгийн ялмагт хөрстэй өндөр уулын нуга</i>	
12	81	ӨХ-I-2-1	Жижиг дэгнүүлт үетэн - алаг өвс - бушилзат	1223,8
		<i>ЦХ-I</i>	<i>Анги : Гүвээрхэг болон тэгшивтэр хөндийн цайвар хүрэн ба бор хөрстэй цөлөрхөг хээр</i>	
13	147	ЦХ-I-1-6	Монгол өвс- тэсэгт	13659,1
14	149	ЦХ-I-1-8	Монгол өвс-баглуурт	12385,1
15	152	ЦХ-I-1-11	Монгол өвс - таарт	22026,3
16	162	ЦХ-I-3-2	Тэсэгт	45029,7
		<i>Ц-I</i>	<i>Анги: Тэгшивтэр хөндийн бор, бор саарал хөрстэй говийн бэлчээр</i>	
17	168	Ц-I-1-6	Улаанбударгана-бударганат	1237,9
18	171	Ц-I-1-9	Таарт	17630,9
19	181	Ц-I-2-9	Сийрэг загт	224436,3
		<i>Н-I</i>	<i>Анги: Голын хөндий нуурын захын аллювийн нугат намгийн хөрстэй нуга намгийн бэлчээр</i>	
20	194	Н-I-2-1	Улалжит	22119,1
		<i>Н-II</i>	<i>Анги: Аллювийн нугын болон хээржсэн нугын үелсэн сулавтар хөгжилтэй хөрстэй татамын нуга</i>	
21	198	Н-II-1-1	Үетэн-алаг өвст	158,4
22	201	Н-II-2-1	Үетэн-алаг өвст	140,7
23	208	Н-II-4-1	Улалж-үетэн-алаг өвст	11212,3

24	221	Н-Ш-3-2	Дэрс-хиаг-алаг өвст	249,5
25	224	Н-Ш-3-5	Дэрс-жижиг улалжит	4875,6
		Н-IV	Анги: Хужир мараатай нугын хээржсэн хөрстэй нам хотосын нуга	
26	235	Н-IV-2-4	Бударганат	5981,8
27	240	Н-IV-3-3	Зэгс, дэрс, сухайтай тооройн төгөл	15683,4
			Бэлчээрт тохиромжгүй газар	
28	246	БТ-2	Хад, цохио, асга	160,8
29	248	БТ-4	Элс	9694,2
30	249	БТ-5	Мараа, шал	550,2
			Нуур	644,8
			Ой	4978,1

Зураг 15. Ургамалжилтын зураг



2.4.3. Сумын бэлчээрийн ургамалжилтийн төрх байдал, төлөв.

Бэлчээрийн төрх байдал: Сумын нийт нутаг дэвсгэрийн бэлчээрийн төрх байдлын 42.1 хувийг сөөгтэй бэлчээр, 36.7 хувийг чулуутай бэлчээр, 10.7 хувийг довонтой бэлчээр 8.5 хувийг цэвэр бэлчээр тус тус эзэлж байна. Ашиглагдахгүй бэлчээрт 15478 га буюу нийт талбайн 1,9 %-ийг нуур, заган ой, элс, хад асга эзлэж байна.


Сумын бэлчээрийн төрх байдал (талбай,%)

Хүснэгт 14.


Д/д	Хэв шинж	Талбайн хэмжээ /га/	Эзлэх хувь
1	Нуур	644,8	0,1
2	Ой	4978,1	0,6
3	Цэвэр бэлчээр	68873,9	8,5
4	Чулуутай бэлчээр	297916,2	36,7
5	Сөөгтэй бэлчээр	341060,7	42,1
6	Довонтой бэлчээр	86990,7	10,7
7	Элс	9694,2	1,2
8	Хад асга	160,8	0,0
Нийт		8108	100

Сумын бэлчээрийн төрх байдлын эзлэх хувь

Диаграмм 13.



Зураг 16. Бэлчээрийн төрх байдлын зураг



Бэлчээрийн төлөв байдал: Сумын аж ахуйн үндсэн чиглэл нь уламжлалт мал аж ахуй эрхэлдэг бөгөөд бэлчээрийн даац 2,9 дахин хэтэрсэн байгаа нь бэлчээр талхлагдаж байгааг харуулж байна. Баянгол багийн голын хөндийн, нам хотосын нугийн бэлчээр их талхлагдсан байгаа нь нүүдлийн гол зам дайран өнгөрч малын хөлөөр их талхлагдалд орж байна. Мөн Алагтолгой, Далт, Баянсудал багуудын голын хөндийн, нам хотосын нуга, өндөр уулын, дундаж өндөр болон нам, бэсрэг уулын бэлчээрүүд дунд зэрэг талхлагдсан, Байтаг багийн дундаж өндөр болон нам, бэсрэг уулын бэлчээр бага зэрэг талхлагдсан байна.


Нөлөөлөлд өртсөн бэлчээрийн талбай

Хүснэгт 15.


№	Нөлөөлөлд орсон	Талбайн хэмжээ /га/	Эзлэх хувь
1	Доройтолд ороогүй бэлчээр	763634	94.2
2	Доройтолд орсон бэлчээр	46869	5.8
Үүнээс	Их талхлагдсан	21324	1.3
	Дунд зэрэг талхлагдсан	10133	2.6
	Бага талхлагдсан	15412	1.9
	Нийт	46869	5.8
	Нийт	810503	100

Нөлөөлөлд өртсөн бэлчээрийн талбайн эзлэх хувь

Диаграмм 14.



Зураг 17. Бэлчээрийн төлөв байдлын зураг



2.5. ОЙН НӨӨЦ, ТӨЛӨВ БАЙДАЛ**2.5.1. Сумын ойн нөөц.**

Сумын урд хэсэг буюу Байтаг баг, Алаг толгой багийн урд хэсгээр заган ой тархсан бол Булган гол дагаад бургас улиас бага хэмжээгээр тархсан байна. Ой нийт талбай нь сумын нутаг дэвсгэрийн 28,1 хувийг эзэлж байна.


Сумын нутаг дэвсгэрт тархсан ойн төрөл

Хүснэгт 16.


Д/д	Ойн төрөл	Талбай, га	Нийт нутаг дэвсгэрт эзлэх хувь
1	Бургас	1256,5	0.2
2	Заг	223244,2	27.5
3	Сухай	0,6	0.00
4	Улиас	789,9	0.1
5	Цагаан энгэр	2,7	0.00
6	Шинэс	2929,1	0.4
Нийт		228222.9	28.1

Ойн төрөл /хувиар/

Диаграмм 15.



Зураг 18. Ойн төрлийн зураг



2.5.2. Ойн төлөв байдал.


Ойгоор бүрхэгдсэн талбай нь ойн нийт талбайн 17,7 хувийг эзэлж байгаа бол ойгоор бүрхэгдээгүй нь 82,3 хувийг эзэлж байна. Хамгийн их хувийг тармаг заг 81,5 хувийг, дунд насны заг 15,4 хувийг тус тус эзэлж байна. Ойн ашиглалт байхгүй тул төлөв байдалд хүний хүчин зүйлийн нөлөөгүй байгаль цаг уурын аясаар өөрчлөлт нь явагдаж байна.

Ойн төлөв байдал /талбай, %/

Хүснэгт 17.

<i>Д/д</i>	<i>Ойн төлөв байдал</i>	<i>Талбайн хэмжээ /га/</i>	<i>Эзлэх хувь</i>
Ойгоор бүрхэгдсэн			
1	Болц гүйцсэн улиас	38,79	0,02
2	Болц гүйцсэн шинэс	2615,27	1,15
3	Болц гүйцэж буй бургас	483,23	0,21
4	Болц гүйцэж буй заг	1953,42	0,86
5	Болц гүйцэж буй шинэс	64,84	0,03
6	Дунд насны заг	35177,34	15,41
7	Сухай	0,59	0,00
Ойгоор бүрхэгдээгүй			
8	Тармаг бургас	773,23	0,34
9	Тармаг заг	186113,46	81,55
10	Тармаг улиас	789,89	0,35
11	Тармаг шинэс	210,16	0,09
12	Цагаан энгэр	2,70	0,00
Нийт		228222,92	100,00

Зураг 19. Ойн төлөв байдлын зураг



2.6. ГАДАРГЫН БОЛОН ГҮНИЙ УСНЫ НӨӨЦ**2.6.1. Гадаргын усны нөөц.**

Булган сум нь нийт 252 гадаргын устай бөгөөд үүнээс 143 булаг, шанд, 96 худаг, 2 нуур, 11 голтой /гадаргын усан хангамжийн дэлгэрэнгүй мэдээллийг *хавсралт 1*-д харуулав/. Гадаргын усан хангамж харьцангуй сайн бөгөөд Булган гол болон түүний ай савын нөлөө юм.

Сумын уст цэгийн тоо

Хүснэгт 18.

Багийн нэр	Булаг	Худаг	Гол	Нуур	Дүн
Алагтолгой	52	4	3		59
Баянгол	42	22	2		66
Байтаг	38	53	6	1	98
Баянсудал	11	8		1	20
Бүрэнхайрхан		5			5
Далт		4			4
Нийт	143	96	11	2	252

Булган гол Монгол Алтайн нурууны салбар Баян-Өлгий аймгийн Булган сумын нутгаас эх авч урсадаг ба зүүн талаас Улаагчин, Улаан даваан голууд нийлэн Ёлтын голд цутган урссаар Булган голд нийлдэг. Мөн Түргэн, Хужирт, Дээд Нарийн, Доод Нарийн, Улиаст зэрэг томоохон голууд, Хуурай, Түргэн, Чацарт, Хар дав, Өмнө Цөө, Уст болон Хуурай Мэлхийтийн жижиг голууд цутгана. Голын баруун талаас Их Жаргалант, Дунд, Нарийн Жаргалантын голууд, Цагаан Бургаст, Туулайт, Олон Ендэрт, Их, Дунд, Мухар Төмөртийн голууд, Ендэрт, Хулстай, Тошилт, Жаргалт, Хойд Цөө, Баянгол зэрэг уулын түргэн урсгалтай голууд цутгадаг. Булган голын сав газар нь гадаргын цэнгэг усны асар их нөөцтэй бөгөөд Хар нуур, Ногоон нуур, Их Түргэний нуур, Сөнхөл, Баяннуур, Сэрүүн нуур, Хөх голын нуур, Цоохор нуур, Гашуун нуур зэрэг том жижиг нууруудтай. Булган гол нь Монгол улсын нутаг дээгүүр 312 км урсан Хятад улс руу гардаг, гадагш урсгалтай, хилийн цөөн тооны голын нэг. Булган голын ус хуралдуулах талбай 8750 орчим хавтгай дөрвөлжин км бөгөөд усны уналт голын нийт уртад 1900 м буюу Дундаж налуу нь 0,0076 болно. Булган гол нь далайн түвшнөөс дээш 1155 м-ээс дээш өндөрт өргөгдсөн.

Булган голын сав: Монгол Алтайн нурууны мөнх цаст оргилууд байрладаг нь түүний байгалийн нөхцөлд ихээхэн нөлөө үзүүлдэг онцлогтой. Булган голын савд Алтайн өндөр уулсын өвөр бэлийн хадан цохио, ханан хавцлууд багтах тул голын хөндий өргөн нь ихэнхдээ 0,3 -0,5 км байснаа баруун гарын цутгал Баянголын амнаас доош уужим болдог. Булган голын эхэн болон цутгал жижиг голын уулзварт эртний мөстлөгөөс тогтсон морены хурдас, үхэр чулуу ба хонин дух чулуу элбэг байдаг. Голын гольдирлын өргөн 10-60 метр гүн 0,5-1,5 метр боловч зарим цүнхэл хэсэг, хар ус бүхий тохойд 4-5 метр гүнзгий байдаг, урсгалын хурд нь голын дээд хэсэгт 2-2,5 м/сек адагтаа 0,3-0,4 м/сек болж буурна.

Голын усны химийн найрлага нь гидрокарбонат бүхий устай юм. Сав газрын 96%-ийг бэлчээрийн газар эзэлдэг, биологийн олон янз байдалтай ба Монголын улаан номонд орсон нэн ховор амьтан болох Минж, Цоохор ирвэс, Аргаль, Янгир, Халиун буга, Ойн унтаахай зэрэг амьтдаас гадна Зүүн гарын гоёо, Залаархаг хавраг буюу Чийр, Элдэвнавчит улиас, Ноосоншилбэт баглуур, Өндөр баглуур, Зүүнгарын бачир зэрэг ховор, нэн ховор ургамалуудтай. Сав газрын хамгийн өндөр цэг нь Дэрвээдэг уул д.т.д.3501м, хамгийн нам доор газар Цоохор нуурын орчимд д.т.д.1100 м юм.

Зураг 20. Гадаргын усны зураг



2.6.2. Гүний усны нөөц.

Сумын нийт нутаг дэвсгэрийн дийлэнх хувийг Мезозойн болон палеозойн үеийн интрузив чулуулгийн ан цав дахь усжилттай бүс, голуудын хөндий, эрэг орчимоор орчин үеийн болон дээд дөрөвдөгчийн үеийн ус агуулсан давхарга эзэлж байгаагаас үзэхэд гүний усны нөөц харьцангуй элбэгтэй нутаг болно.

Сумын гидрогеологийн нөхцөл: Гидрогеологийн мужлалаар Ховд аймгийн Булган сум нь хойт хэсгээрээ Баруун буюу Монгол Алтайн дэд муж (булганы грунтын усны ай савд) хамаарагдах ба төв болон урд хэсгээрээ Өмнөд буюу Өмнөговийн дэд мужид (баруун хурайн ай савд) хамаарагддаг байна.

Сүвэрхэг /атрижаагүй/ чулуулаг.

Их ус ханамжийн уст бүрдэл, усаар бага ханасан уст бүрдэл, хэсэгчилэн усаар хэт ханасан ба голчилон дунд зэрэг усаар ханасан уст бүрдэлүүд, усаар сул ханасан уст бүрдэлүүд, бараг усжилтгүй чулуулаг гэж гидрогеологийн нөхцөлийг ялгасан. Их ус ханамжийн уст бүрдэл нь сумын хэмжээнд маш бага талбайд тархсан ба байтаг багийн зүүн урд хэсэгт багахан талбайд салхины хуримтлалаар үүссэн элс, харин байтаг багийн зүүн хойт хэсэгт нуур-голын, нуур-пролювийн гарал үүсэлтэй хайрганцар, элс, элсэнцэр, шавранцар, шавар, алаг толгой багийн хойт их онгогийн хөдөө хэсэгт гол-пролювийн гарал үүсэлтэй элс, хайрга, хайрганцар, бул чулуу, элсэнцэр, шавранцар хурдасууд тархсан байна.


Цул ан цавт чулуулаг.

Усаар бага ханасан уст бүрдэл ерөнхийдөө сумын алаг толгой, далт, бүрэгхайрхан, баянсудал, байтаг багууд зонхилон тархсан ба ихэвчлэн гарал үүслийн хувьд салхин хуримтлалын элс, гол-пролювийн гарал үүсэлтэй элс, хайрга, хайрганцар, бул чулуу, элсэн, шавранцар зонхилон тархсан ба газрын доорх усны байрлах гүн 0-10 м байна. Хэсэгчилэн усаар хэт ханасан ба голчилон дунд зэрэг усаар ханасан уст бүрдэлүү нь сумын урд хэсэг болох байтаг багийн төв хэсгээр, хойт хэсэг болох алаг толгой, баянгол, баянсудал багуудад ихэвчлэн байх ба элсжин хөрзөн алевролит, аргиллит, хайргажин, занар болон брекчи, цахиржин, боржин, боржин диорит, граносиенит, диорит зэрэг хурдас чулуулгууд байна. Бараг усжилтгүй бүс.

Сумын нутаг дэвсгэрийн тал хувийг эзлэх буюу байтаг болон алагтолгой багуудад ихэвчлэн байх ба боржин диорит, граосиенит, диорит, элс, шавар, алевролит, алетрит, ховроор элсжин, хайргажин, хөрзөн, брекчи, цахирчин зэрэг хурдас чулуулагт байна.

Сумын хэмжээнд газрын доорх усны илэрц болох худаг болон цооногийн химийн найрлага нь хлор, гидрокарбонат, гидрокарбонат-сульфат найрлагатай гэсэн мэдээ байна.

Зураг 21. Гидрогеологийн зураг



2.7. ИНЖЕНЕР ГЕОЛОГИЙН НӨХЦӨЛ

2.7.1. Инженер геологийн мужлал.

Сумын нутаг дэвсгэр нь Монгол орны инженер геологийн мужлалын хувьд Монгол Алтайн болон Алтайн өвөр говийн их мужийн залгаа хэсэгт ба сэвсгэр ул хөрсөөр алаг цоог хучигдсан хадан чулуулаг бүхий өндөр уул, нам уул, ухаа толгодорхог тогтоцтой олон жилийн цэвдэг үргэлжилсэн тархалттай Мөнххайрхан, Байтаг богд-Тахийн шар, олон жилийн цэвдэг алаг цоог тархалттай Булган гол, Үенчин болон олон жилийн цэвдэг тархаагүй Баруунхуурайн гэсэн 5 мужуудыг дамнан орших ба инженер геологийн нийлмэл тогтоцтой газар нутаг байна.

Геологийн тогтоц ба ул хөрсний тархалт:

Кайнозой эриний хурдас- Дөрөвдөгчийн галавын_(a, ap, La, LQ_{IV}): Голцены настай, аллюви, нуур-аллювийн гаралтай ул хөрс голын голдирол ба татам, нуурын хэсгээр буюу Байтаг багийн зүүн урд хэсэг болон хойд хэсэгт, Алагтолгой багийн зүүн хэсгээс баруун тийш хөндлөн огтлосон Булган голын хөндийд Далт болон Баянсудал багийн нутаг дэвсгэрээр элс, шавар, хайргажин элсэнцэр, шавранцар, давс, бул чулуу, сэвсүүл элс хэлбэрээр тохиолдоно.


Плейстоцен (d,dpQ_{III}) - Делюви-солифлюкцийн, делюви-пролювийн, коллювийн гарал үүсэлтэй ул хөрс нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд ихээхэн талбайг хамран тархсан ба голдуу голын хөндий, нуур орчим уулсын бэл дэнжээр хайрга, хайрганцар, дайрга, дайрганцар, үйрмэг агуулсан шавранцар, элсэнцэр, элс зэргээр элсэнцэр, шавранцар, шавар, мараа бүхий бүрэлдхүүнтэйгээр тохиолдно.

Неогоны галавын (N₂) - Плиоцен ба миоцен настай хурдас нь Байтаг багийн нутаг дэвсгэрт ихэвчлэн тархах ба нутгийн өмнөд болон төв хэсгээр голчлон пролювийн гарал үүсэлтэйгээр улаан-хүрэн, шаргалдуу-хүрэн өнгийн хайрга, хайрганцар, үйрмэг, дайрганцар бүхий элс, элсэнцэр, элсжин, хайргажин, хөрзөн, шүлтлэгдүү хүрмэн, андези хүрмэн саарал, ногоон, алаг, улаан өнгийн шавар, алеврит, бул чулуу, хайрга, хайрганцар элс, өөш формацад цайвар-саарал өнгийн элсжин, шавар, алеврит, мергел, хайрга зэрэг хурдас чулуулгаас тогтоно.

Палеозой эриний хурдас- Түрүүн-дунд карбоны гүний бүрдэл. Баруун хуурай бүрдэлд орших ба байтаг багийн төв хэсгээр аллюви, аллюви-пролювийн гарал үүсэлтэйгээр биотит эвэрхуурмагт, биотитэт, шүлтлэгдүү лейкократ чулуулгаар тархсан байна.

Сумын нутаг дэвсгэрийн ул хөрсний тархацыг гарал үүслийн хувьд Голын, Гүний, Моласслаг бялхамал, Моласслаг бялхамал тунамал, Нуур-голын, Нуурын, Солифлюкц-делювийн, Элювийн ба солифлюкцийн гэж ялгасан байна.

Зураг 22. Геологийн зураг



2.7.2. Геоморфологийн тогтоц

Тектоник-элэгдлийн хэв шинжит хотгор гүдгэр


Эртний мөсдлийн үйлчлэлээр хэлбэржин тогтсон гадаргатай, орчин үеийн үйл явц эрчимтэй илэрсэн их хэрчигдэлтэй уулс ба нуур намаг бүхий хавтгай оройтой их хэрчигдэлтэй өндөр уул хэсэг нь сумын урд үзүүр болон хойд хэсгээр /2400-3392 м/ өндөршилттэй газрын хэвгий нь зарим хэсэгтээ 32 градусаас дээш огцом налууутай.

Уулс хоорондын хотос, уулс дотоодын хөндий, хотгор дахь элэгдлийн хэвшинжит өргөгдмөл хотгор гүдгэр, тэгширмэл газар голын хөндий дэх хуримтлалын хэвшинжит хотгор гүдгэр гадаргуу зонхилно.

Ихээхэн хэрчигдсэн, хавтгай бөмбөгөрдүү оройтой эгц хажуутай дундаж өндөр уулархаг гадаргуу нь Баянсудал багийн төв болон баруун урт хэсэгт /983-1400м/ өндөршилттэй газрын хэвгий 0-12 градус. Дунд зэргийн болон сул хэрчигдсэн бөмбөгөрдүү оройтой, эгц хажуутай дундаж өндөрхөг уулс, эгцдүү хажуутай дундаж өндөр уул, хярласан үлдэц нам уулс сумын хэмжээнд ихэвчлэн тархсан байна. Алюви-пролювийн гаралтай нимгэн хусааст гүвээт гадаргуу нь байтаг багийн ихэнх нутаг дэвсгэрт тааралдана. Бүрэнхайрхан, Баянсудал, Далт, Алагтолгой багуудийн нутаг дэвсгэрийн гадаргуу нь орчин үеийн татам, сайрын хөндий ба ёроол, нам дэнж бүхий алювийн тал ба өндөршилтийн хувьд харьцангуй нам дор /983-1200м/ өндөршилттэй газрын хэвгий нь 0-4 градус байна. Байтаг багийн зүүн болон баруун хэсэгт бага талбайд нуур-алювийн тал зонхилон байна.

Гадаргын өндөршилийн хувьд байтаг баг хойд хэсгээрээ нам дор дэнж толгодрохог хэсэг /983-1200м/ оосоо урагш ерөнхийдөө өндөршилт ихссэн урьд хэсгээрээ уулархаг /2400-3392м/ хүртэлх өндөршилттэй байна.

Зураг 23. Геоморфологийн зураг



2.7.3. Цэвдгийн нөхцөл

Сумын олон жилийн цэвдэгийн тархалт: Баянгол болон Баянсудал багийн нутаг дэвсгэрээр хойд хэсгээр ерөнхийдээ олон жилийн цэвдэг чулуулаг алаг цоог тархалттайгаар тархсан ба урд хэсгээрээ олон жилийн цэвдэг чулуулаг ховроор буюу алаг цоог тархалттайгаар тархсан байна. Харин далт болон бүрэнхайран багууд нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд, алагтолгой, баянсудал, байтаг багуудын нутаг дэвсгэрийн хойд хэсгээр олон жилийн цэвдэг чулуулаг нь тохиолдлын тархалттайгаар оршино байна. Баясудал, алагтолгой, байтаг багуудын урд хэсгийн ерөнхийдөө улирлын маягийн цэвдэг чулуулаг үүсдэг бүс бүслүүрт багтаж байна. Нийт нутаг дэвсгэрийн 71,1 хувь нь ховор алаг цоог тархалттай, 23.4 хувь нь алаг цоог тархалттай, 5.5 хувь нь олон жилийн цэвдэг чулуулаг үргэжилсэн тархалттай байна.


Сумын олон жилийн цэвдэгийн тархалт

Хүснэгт 19.


Цэвдэгийн тархалтын нэр	Талбай /га/	Эзлэх хувь
Олон жилийн цэвдэг чулуулаг тохиолдлын тархалттай	218958.3	27.02
Улирлын цэвдэг чулуулаг үүсдэг бүслүүр	453480.6	55.97
Олон жилийн цэвдэг чулуулаг ховор алаг цоог тархалттай	47367.1	5.85
Олон жилийн цэвдэг чулуулаг үргэжилсэн тархалттай	15735.6	1.94
Олон жилийн цэвдэг чулуулаг алаг цоог тарха	75328.0	9.2

Сумын олон жилийн цэвдэгийн тархалтын эзлэх хувь

Диаграм 16.



Зураг 24. Цэвдгийн тархалтын зураг




2.7.4. Инженер геологийн үйл явц, үзэгдэл, газар чичирхийлэл

Сумын нутаг дэвсгэрт түр зуурын урсгал усны угаагдлын үйл явц хамгийн элбэг явагддаг бөгөөд Хүрэн өндөрийн сайр зэрэг томоохон сайр, хөндий түүнээс салбарласан олон тооны гуу жалга ажиглагдана. Хур борооны улиралд ул хөрс шингэрэх буюу намагжих үйл явц эрчимжих бөгөөд Булган голын гольдрол, татмаар намаг элбэг тохиолдоно. Мөн сумын нутаг дэвсгэрийн төв хэсэгт байх Баруун хуурай, Харганат, Их бага хуурайн түнгэ болон Булган голын хөндийг дагаад Нуурын түнгэ зэрэг хөрсний давсжилтын үйл явцын үр дүнд бий болсон хужир марзууд тархсан байна. Физик геологийн үйл явц үзэгдлийг нарийвчлан судлах шаардлагатай.

Газар чичирхийлэл: Алагтолгой багийн төв хэсэг, Баянгол ба Баянсудал багийн өмнөд хэсэг, Далт ба Бүрэнхайрхан багийн нутаг дэвсгэр бүхэлдээ газар чичирхийллийн 7 баллын мужид оршин байна. Сумын нутаг дэвсгэрийн төв хэсгээр хөндлөнгөөр рихтерийн шатлалаар 6-7 магнитудийн голомт үүсэж болох бүсийг тодорхойлсон байна. Баянгол, Баянсудал, Байтаг багийн нутаг дэвсгэр ерөнхийдөө газар чичирхийллийн 8 баллын мужид хамрагдаж байна. Байтаг багийн зүүн хэсгээр газар чичирхийллийн 9 болон түүнээс баллын мужид оршин байна.

Зураг 25. Газар чичирхийллийн зураг



2.8. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ**2.8.1. Түүхэн хөгжлийн тойм.**

Булган сум нь 1926 онд Чандмань уул аймгийн “ Булган мандал Бүрэнхайрхан уулын хошуу нэртэй байгуулагдаж хошуу Тамгын даргаар Ач Залаа, нарийн бичгийн даргаар Жаргалсайхан нарыг томилжээ. Хожим Жаргалсайхан Улсын бага хуралд ажиллах болж оронд нь Цэвэг захирагчийг томилжээ.

1931 онд Ховд аймаг шинээр зохион байгууллагдахад Булган сум болон байгуулагдаж даргаар нь Р.Ядамыг томилсон түүхтэй. Ховд аймгийн Булган сум нь Монгол улсын баруун хязгаар, Монгол Алтайн нурууны өвөрт БНХАУ-тай хил залган, улсынхаа нийслэлээс 1588 км, Ховд аймгийн төвөөс 487 км алс оршдог.

Булган нутгийн ард иргэд үндэсний уламжлалт ахуй соёл, зан заншлаараа өвөрмөц онцлогтой, хүн амын 75% -ийг эзлэх торгууд түмэн тус суманд оршин амьдардаг ба казах болон бусад ястан, үндэстэн бий.

2.8.2. Хүн амын одоогийн байдал.

Тус сум нь 2016 оны байдлаар 9561 хүн ам, 2287 өрх айл байгаагаас нийт хүн амын 74.58 хувь нь буюу 7131 хүн сумын төвд, 25.42 хувь буюу 2430 хүн хөдөөд амьдарч байна. Сумын хүн амын нягтшил 1.16 хүн/км.кв байгаа нь Ховд аймгийн бусад сумуудтай харьцуулахад өндөр нягтшилтай байна.

Сумын хүн амын тоо /сүүлийн 3 жилээр/

Хүснэгт 20.

Хүн амын үзүүлэлт		Хугацаа, оноор										
		2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Сумын нийт хүн ам		9582	9634	9695	9515	9266	9266	9018	9203	9547	9452	9561
Үүнээс	Сумын төвийн хүн ам											7131
	Хөдөөгийн хүн ам											2430
Нийт өрхийн тоо		2037	2068	2120	2151	2147	2163	2169	2221	2243	2314	2287
Үүнээс	Төвийн өрх											1734
	Малчин өрх											553
Төрөлт, 1000 хүнд ноогдох		246	229	287	270	223	273	233	269	266	218	141
Нас баралт, 1000 хүнд ноогдох		54	50	44	61	47	62	49	50	55	49	31

Багуудаар харьцуулж үзэхэд Баянсудал баг хамгийн олон хүн амтай хэдий ч хүн амын нягтшилаар 1089.50 км.кв талбайд 2140 хүн ноогдож байна. Хамгийн бага нь Байтаг баг 1343 хүн амтай, 0.34 хүн км.кв нягтшилтай байхад Бүрэнхайрхан баг хамгийн их 168.6 хүн/км.кв нягтшилтай байна. Харин Сумын төв болох Далт болон Бүрэнхайрхан баг нь хүн амын нягтшилаар сумын дундажаас хэд хадин их буюу 40.08 хүн/км.кв, 168.6 хүн/км.кв тус тус байна.


Сумын хүн амын үзүүлэлт, багуудаар

Хүснэгт 21.

Багийн нэр	Хүн амын тоо	Хүн амын нягтшил, хүн/км.кв	Өрхийн тоо
1-р баг, Баянгол	1473	1.43	341
2-р баг, Баянсудал	2140	1.96	442
3-р баг, Байтаг	1343	0.34	354
4-р баг, Алагтолгой	1310	0.65	322
5-р баг, Далт	1440	40.08	405
6-р баг, Бүрэнхайрхан	1675	168.60	450
Сумын нийт	9381	1.16	2314

Сумын хүн ам, өрхийн тоо, багуудаар

Диаграмм 17.



2.8.3. Мал аж ахуйн судалгаа.

Сумын хэмжээгээр нийт 211994 толгой мал байгаагаас 21,3 хувийг хонь, 63,5 хувийг ямаа, 10,5 хувийг үхэр, 3,9 хувийг адуу, үлдсэн 0,9 хувийг тэмээ тус тус эзэлж байна.


Сумын малын тоо, төрлөөр, /2015 он А данс/

Хүснэгт 22.

Багийн нэр	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа	Нийт
Баянгол	1279	3037	162	3645	29001	37124
Баянсудал	1107	2897	427	8898	24141	37470
Байтаг	2536	4669	794	18057	32274	58330
Алагтолгой	1912	5774	388	6223	24605	38902
Далт	650	3030	22	3579	11561	18842
Бүрэнхайрхан	745	2855	55	4659	13012	8314
Сумын нийт	8229	22262	1848	45061	134594	211994
Эзлэх хувь	3.9	10.5	0.9	21.3	63.5	100

Сумын малын тоо, багаар

Диаграмм 18.



Сүүлийн 5 жилийн байдлаар сумын хэмжээнд бүх төрлийн мал өссөн бөгөөд олон жилийн дундажаар 1,09 коэффициентээр өссөн байна. Малын тооны өсөлт нь бэлчээрийн хангамжид сөрөг нөлөө үзүүлэх тул цаашид малын тоог өсгөхгүйгээр, малыг эрчимжүүлэн, чанаржуулах тал дээр анхаарах шаардлагатай.





Сумын малын тооны өөрчлөлт, сүүлийн 5 жилээр

Хүснэгт 23.


Он	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Тэмээ	Бүгд
2011	6041	1349	2687	98003	1675	110091
2012	6344	15037	32452	98052	1705	65697
2013	6221	15614	32479	94639	1565	150966
2014	7374	19427	41272	120044	1733	82131
2015	8229	22262	45061	134594	1848	212161
НИЙТ						

Сумын малын тооны өсөлт, төрлөөр

Диаграмм 19.



Зураг 26. Мал сүргийн бүтэц



III. ГАЗАР, БАЙГАЛИЙН НӨӨЦ ЭДЭЛБЭРИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**3.1. ГАЗРЫН НЭГДМЭЛ САН**

Булган сумын нутаг дэвсгэрийн хил хязгаарт 2012 онд ГХГЗЗГ-аас хийгдсэн Улсын аймаг, сумдын хилийн цэсийн өөрчлөлтийн ажлаар өөрчлөлт хийсэн зургийг ашигласан болно. Үүнээс үзэхэд багахан хэмжээгээр 1.2 га-аар багассан байна.

Сумын газрын нэгдмэл сангийн ангилалын талбайн зөрүү


Хүснэгт 24.

Газрын нэгдмэл сангийн үндсэн ангилал	Хөдөө аж ахуйн газар	Хот тосгон бусад суурин газар	Ойн сан бүхий газар	Усны сан бүхий газар	Зам шугам сүлжээний газар	Улсын тусгай хэрэгцээний газар	Нийт
Газрын нэгдмэл сангийн тайлан	603999.1	5206.94	196699	3166.7	1788.1	9.3	810868.7
Хэмжилтээр	571066.4	6505.61	225755	1837.24	5684.15	18.8	810867.5
Зөрүү +/-	32932.7	-1298.67	-29056	1329.46	-3896.05	-9.5	1.2

Сумын газрыг нэгдмэл сангийн ангиллаар нь авч үзвэл хөдөө аж ахуйн газар болон усны сан бүхий газар хасагдаж бусад ангиллын газрууд нь нэмэгдсэн байна. Энэ нь хөдөө аж ахуйн газраас бусад ангиллын газар шилжүүлэн авч газар ашиглалт явагддагтай холбоотой юм.

Нийт сумын газрын 70.4% буюу 571066.4 га нь хөдөө аж ахуйн газар, 0.8% хувь буюу 6505,61 га нь хот тосгон бусад суурины газар, 0.7% буюу 5684,1 га нь зам, шугам сүлжээний газар, 27,8% буюу 225755 га талбайг ойн сан бүхий газар, 0.2% буюу 1837,2 га нь усан сан бүхий газар, 0,002% буюу 18,8 га нь улсын тусгай хэрэгцээний газар тус тус эзэлж байна.

Зураг 27. Газрын нэгдмэл сан



3.2. СУМЫН ГАЗАР АШИГЛАЛТЫН ОДООГИЙН БАЙДАЛ

Булган сумын газар ашиглалт 90 орчим хувийг бэлчээрийн зориулалтаар ашиглаж байгаа бөгөөд төв суурин газар жимс жимсгэнэ, төмс хүнсний ногоо, хадлан хаших, өрхийн хэмжээний үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх зорилгоор үйл ажиллагаа явуулж байна. Тус суманд нийт 144 хуулийн этгээд үйл ажиллагаа явуулж байгаа ба *хавсралт 2*-д дэлгэрэнгүйгээр харуулав.


Сумын газар ашиглалтын талбай

Хүснэгт 25.


Үндсэн ангилал	Код	Дэд ангиллын түвшин	Ашиглалтын байдал	Эзлэх талбай	
				Га	Хувь
Хөдөө аж ахуйн газар	1	Бэлчээр	өвөл-хаврын	468931.917	57.8309
			зун-намрын	58091.668	7.1641
			усжуулагдаагүй	41313.415	5.0950
		Хадлан	ердийн	27.744	0.0034
		Усалгаатай тариалан	үр тариа	2126.307	0.2622
		ХАА-н барилга, байгууламжийн газар	өвөлжөө, хаваржаа	541.816	0.0668
		бэлчээр дэх уст цэг	33.559	0.0041	
Хот, тостон, бусад суурины газар	2	Барилга, байгууламжийн газар	төрийн захиргааны байгууллага	2.201	0.0003
			урлаг, соёлын байгууллага	0.114	0.0000
			боловсролын байгууллага	7.480	0.0009
			эрүүл мэндийн байгууллага	1.147	0.0001
			банк, санхүүгийн байгууллага	0.199	0.0000
			нам, олон нийтийн байгууллага	0.193	0.0000
			сүм, хийд, шашны байгууллага	3.476	0.0004
			худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор	1.688	0.0002
			дэд бүтцийн байгууллага	0.008	0.0000
			шатах, тослох материал түгээгүүрийн газар, агуулах, ШТС	2.505	0.0003
		ус түгээх цэг	0.001	0.0000	
		Сууц	4 ба түүнээс доош давхар нийтийн орон сууц	0.148	0.0000
			амины орон сууц		0.0000
			гэр, орон сууцны хашааны газар	921.537	0.1136
		Нийтийн эзэмшил	цэнгэлдэх хүрээлэн, наадмын талбай	3.155	0.0004

			нэрэмжит талбай, хөшөө, дурсгалын газар	0.817	0.0001
			эээмшил, ашиглалтанд олгогдоогүй сул чөлөөтэй газар	5512.478	0.6798
			хогийн цэг	4.680	0.0006
			оршуулгын газар	39.857	0.0049
		Аялал жуулчлал	аялал, жуулчлалын бааз	3.922	0.0005
Зам, шугам сүлжээний газар	3	Авто замын газар	хатуу хучилттай зам	2124.234	0.2620
			сайжруулсан шороон зам	2030.265	0.2504
			ердийн шороон зам	1329.471	0.1640
			авто замын барилга, байгууламж	0.001	0.0000
	Агаарын тээврийн газар	нисэх, буух зурвас	6.138	0.0008	
		хамгаалалтын зурвас	59.168	0.0073	
		агаарын тээврийн барилга, байгууламж, төхөөрөмжийн талбай	2.089	0.0003	
	Шугам, сүлжээний газар	холбоо, мэдээлэл дамжуулах хүлээн авах станц, шугам	16.545	0.0020	
эрчим хүч, дамжуулах шугам, станц		116.244	0.0143		
Ойн сан бүхий газар	4	Ой модоор бүрхэгдсэн газар	ой модоор бүрхэгдсэн	4864.625	0.5999
			заган ойгоор бүрхэгдсэн	220887.987	27.2409
		Ойн цоорхой	ойн цоорхой	2.703	0.0003
Усны сан бүхий газар	5	Мөрөн, гол, горхи	Мөрөн, гол, горхи	1279.197	0.1578
		Булаг, шанд	Булаг, шанд	0.479	0.0001
		Нуур, цөөрөм, тойром	Нуур, цөөрөм, тойром	556.470	0.0686
		Мөнх цас, мөсөн гол	Мөнх цас, мөсөн гол	1.098	0.0001
Тусгай хэрэгцээний газар	6	ТХГН	Байгалийн нөөцийн газар	9.508	0.0012
		Улсыг батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар	Улсыг батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар	9.265	0.0011
		Шинжлэх ухаан, технологийн сорилт туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай	Шинжлэх ухаан, технологийн сорилт туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай	0.067	0.0000
ДҮН				810867.58	100.0

Зураг 28. Суурин газрын Кадастрын зураг



Зураг 29. Газар ашиглалтын зураг



3.2.1. Бэлчээр ашиглалт.

Сумын хэмжээгээр 550 орчим өрхийн 2530 орчим малчин иргэд байгаа бөгөөд тус сумын нутаг дэвсгэрт нийт 833 өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржааг эзэмшиж бэлчээрийг ашиглаж байна. Энэхүү малчдын бэлчээр ашиглалтын 833 байршил байгаагаас өвөлжөө 367, хаваржаа 182, өвөлжөө-хаваржаа 275 тус тус байна /хавсралт 3-д өвөлжөө, хаваржаа эзэмшигчийн судалгааг харуулав/. Бэлчээр ашиглалтын хувьд байгалийн тогтоц нөхцөлөө даган жилийн 4 улирал нүүдэл хийдэг бөгөөд тэр дундаа Байтаг багийнхан жилийн турш ойролцоогоор 500-800 км нүүдэллэдэг байна.

Өвөлжөө, хаваржааны тоо


Хүснэгт 26.

Д/д	Багийн нэр	Талбай /га/	Малчдын байршил /тоогоор/					Дүн
			Өвөлжөө	Хаваржаа	Өвөлжөө, хаваржаа	Зуслан	Намаржаа	
1	Алагтолгой	200209.53	188	20	26	2		236
2	Баянгол	102827.05	71	59	125	3		258
3	Байтаг	394296.94	73	48	94			215
4	Баянсудал	108949.77	35	55	30	2	2	124
ДҮН			367	182	275	7	2	833

Сумын хэмжээнд уламжлалт мал аж ахуй эрхэлдэг бөгөөд малын төрлүүдээс ямааг түлхүү өсгөн маллахаас гадна хонь, үхрийг голлон өсгөж байна. Эрчимжсэн хэлбэрээр мал маллахгүй байгаа ба уламжлалт, улирлын аясыг даган нүүдэллэж аж ахуйгаа эрхлэж байгаа нь Монгол түмний нүүдлийн мал аж ахуйн аугаа соёлыг хадгалан авч үлдсэн байна.

Баянгол баг хамгийн бага бэлчээрийн газартай хэрнээ 258 буюу хамгийн их өвөлжөө, хаваржаатай байна. Баянсудал багийн хувьд өвөлжөө хаваржааны тоо бага /124/ байгаа нь бэлчээр нутгийн хэмжээний хувьд боломжийн боловч байгалийн төрх байдал, төлөв, тогтоц нь өвөлжиж хаваржихад тохиромжгүй нутагтайг харуулж байна.

Зураг 30. Малчдын нутагладаг байршил зурга



3.2.2. Бэлчээрийн даац.

Сумын хэмжээгээр нийт бэлчээрийн даац төвийн багуудад их хэтрэлттэй байгаа нь суурин газар мал маллаж байгааг харуулж байна. Цаашид суурин газар тэр дундаа сумын төвд мал аж ахуйг эрхлэлтийг багасгаж суурин газраа эрчимжсэн мал аж ахуйн бүс тогтоож тэндээ өндөр ашиг шимтэй эрчимжсэн аж ахуйг хөгжүүлж эрхлэх хэрэгтэй юм. Хөдөөний багуудын хувьд авч үзвэл Баянгол багийн бэлчээрийн даац хамгийн бага зэрэг хэтрэлттэй, Баянсудал, Алагтолгой, Байтаг багуудын хувьд даац хэтрэлт байхгүй байна.


Сумын бэлчээрийн даац, багаар

Хүснэгт 27.


Багийн нэр	Малын тоо /хонин толгой/	Талбай /га/	Га-ийн ургац /цн/	Тэжээлийн нөөц, цн	Жилд идэх өвс /цн/	Багтаамж /хонь толгой/	Даац /хувь/
Баянгол	54,080	102922.24	2.05	210990.592	4.2	50235.9	107.7
Баянсудал	36,227	108854.55	2.14	232948.737	4.2	55464.0	65.3
Байтаг	91,316	394299.36	2.01	792541.7136	4.2	188700.4	48.4
Алагтолгой	75,486	200211.01	1.61	322339.7261	4.2	76747.6	98.4
Далт	7,265	3590.12	2.71	9729.2252	4.2	2316.5	313.6
Бүрэнхайрхан	7,260	992.22	2.75	2728.605	4.2	649.7	1117.5

Сумын бэлчээрийн даац хувиар

